



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/БЗ

Пионер толгой

"Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн
хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5, Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 63 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2021 оны 350 дугаар тогтоол, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн "Бүх нийтээр мод тарих сарын ажлыг зохион байгуулах тухай" 12 дугаар тушаал, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 10/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг орон нутагтаа хэрэгжүүлж, Бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулж, айл өрх бүрийг мод тарих арга хэмжээнд уриалах, татан оролцуулах ажлыг 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 30-ны хооронд зохион байгуулсугай.

2.Мод тарих, арчлах ажлыг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ш.Нархүү), орон нутгийн уур амьсгалд зохицсон тарьц суулгацыг судлан албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд нийлүүлэх ажлыг Байгаль хамгаалагч (М.Бат-Эрдэнэ) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах тарьц, суулгац, тээвэрлэлттэй холбоотой шатахууны үнэ болох 593750 (Таван зуун ерэн гурван мянга долоон зуун тавь) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Тамгын газрын дарга (Р.Гантулга), нягтлан бодогч (Б.Дэлгэрдалай) нарт зөвшөөрсүгэй.

4.Зархирамжийн хэрэгжилтийг хангуулан, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Сүглэгмаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА



642201315

Е/2023/Засаг дарга/Захирамж2023